

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дагва	Дугаар	L140
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Түвшинширээ
Төрсөн газар	Баяндэлгэр	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Бударганы хийд, Өгөөмөрийн хийд	Сүм хийдийн дугаар	СББД 025 СББД 026
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 27	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Бударганы хийд, Өгөөмөрийн хийд

-Та багадаа ямар хийдэд сууж байв?

Би багадаа 5 настайгаасаа 8 нас хүртлээ Бударганы хийдэд сууж байсан. 300 гаруй шавьтай эзэн хааны мэдлийн, чийга ямпайтай тэр урт нурууг нь дагасан хийдүүдийн хамгийн том хийд байсан Бударганы хийд гэж.

-Дарьгангын хошууны хийд үү?

Дарьганга хошууны хийд 5 дацантай, би тэр Бударганы хийдийг л голчилж мэднэ дээ. Дүйнхор, Эхийн хурал, Чойр, Жүд, Манба гэсэн 5 дацантай, толгойлох лам нар нь дандаа маарамба, аграмба байсан. Намайг сүм дээрээс 1934 онд танхимд суулгана гээд аваад гарсан Тэгэхэд сүм хийд тараагүй байсан. Намайг гарсанаас хойш жил болоод тарсан юм гэнэ лээ.

Бударганы хийд гээд нэг хийд байсан тэр дээр нэг суварга байгаа биз дээ, тэр суврагыг би өөрийнхөө лам багш нарт зориулж хийсэн, дэргэд нь жаахан байшин байна уу?

-Байна, урд нь байшин байна лээ.

Тэнд жил болгон зуны тэргүүн сарын шинийн найманд Санжод монлам тогтмол хурдаг.

-3 хоног хурдаг гэсэн үү?

Нэг л хоног хурдаг.

-Баяндэлгэрийн лам нар хурдаг гэсэн үү?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Баяндэлгэрийн лам нар. Зүүн талын Хонгорын хийд гэж байсан. Түүнээс зүүн тийш 48 орчим км газар Өгөөмөрийн сүм гэж жаахан сүм байсан тэр хийдийн талаар дуулсан биз дээ.

-Яахав ээ ганц нэг мэдэх хүнтэй ярилцсан юм бий.

Гурван жаахан дацантай, Өгөөмөрийн хийд гэж байсан, Өгөөмөрийн цагаан ламхай Данзанням гэж лам байж байгаад баригдсан. Түүнээс зүүн тийш Ширээтийн хийд гэж байсан. Тэр одоо Баяндэлгэр сумын төвд хийд нь байгаа. Тэгээд зүүн тийш Байшинтийн хийд гэж байсан тэр нь одоо Хонгор сумын төвд Байшинтын суврага байгаа. Баяндэлгэрийн лам нар мэднэ. Тэрийг би сайн мэдэхгүй. Байшинтын хийдэд яахав цам гардаг том хийд байсан юм гэнэ лээ. Тэр лүү би явж сууж ч үзээгүй. Тэрнээс наашлаад Түвшинширээ, Уулбаяны баруун урагш Түвшинширээгээс зүүн урагш Ламын хийд гэж байгаа. Лагтад нэг суврага байгаа биз дээ тэрний талаар Баяндэлгэрийн лам нар сайн мэдэж байгаа. Ном ч гарсан байгаа. Мэргэн цагаан лам гэдэг байхаа, ном гарсан байгаа мөн 2004 оны “Билгийн мэлмий” сонинд тодорхой бичсэн байна лээ. Орлойн мэргэн лам гэдэг. Орлойн мэргэн амбан биш шүү. Орлойн мэргэн амбан, Орлойн мэргэн цагаан лам, Орлойн лам гэсэн 3 хүн байгаа юм. Би өөрөө Баяндэлгэрийн нутгийн одоо Бударганы хийдийн баруун хойд талаар нутаглаж байсан хүн. Тэгээд 5 настай сүм дээр суугаад 8 настай намайг танхимд суулгана гэж аваад гарсан тэгээд тэрнээс хойш мэдэх юм байхгүй. Сүүлд нь 1994 оноос тэр сүмд хуучин сууж байсан лам багш нарынхаа дурсгалд, одоогоор бол дурсамж хуучнаар ярих юм бол буюн болгож тэнд нэг суврага бүтээгээд тэгээд жилдээ нэг санжод монлам хуруулдаг болоод тэр сүмээс баруун хойшоо 27 км зайтай Нартын уул гэж асар их тахилгатай уул байсан тэрнийг жил болгон тахиулдаг болгосон. Мөн манай сүмээс урагш Шартолгойн энгэрт жаахан сүм байсан.

-Шартолгой гэж Өгөөмөрөө хэлж байна уу?

Тийм. Өгөөмөрийн тэнд. Цагаантолгой гэдэг л юм. Цагаантолгойн хийдийн хойно жаахан толгой одоо мэдэгдэх юмгүй хоёр голын хооронд ганц нэг юү байна уу үгүй юү. Тэрнийг би олигтой мэдэхгүй. Тэрнийг ер нь жаахан зах зухыг мэдэж юм дуулсан хүн тэр хурлын толгойлогч ламын гэр орон энд танай хийдэд сурч байгаа Жамбал гээд лам байгаа, тэрний гэр нь Гандангийн хойхно байгаа. Эцэг нь Шагдар гэж хүн байгаа. Түүний дээдсүүд нь ёстой тэр Цагаантолгой хийдийн толгойлох лам байсан. Тэр хүн Цагаантолгой хурлаас хальт мулт мэддэг байж мэдэх юм. Тэрний ээжийнх нь ах лам хийдийг эхлэн байгуулсан толгойлж байсан хүн тэгээд баригдаад явсан юм гэнэ лээ. Чүлтэм гэдэг хүн байсан. Чухам ямар хийд дацантай байсныг мэдэхгүй. Манай хийдийн талаар бол 1993 онд Мөргөлийн газар гэж сүм байгуулсан. Бурхан багшийн мэндэлсний өдөр анх Бурхан багшийн шарил Монгол оронд 1993 онд орж заларч ирсэн зуны тэргүүн сарын шинийн арван таванд би гэрээ суллаад Баяндэлгэрээс хэдэн лам нар залж хурал хуруулсан. Тэндээсээ залгуулаад мөргөлийн өргөө гэж зөвхөн мөргөлийн газар байгуулсан. Мөргөлийн газар байгуулаад 15 жил хэдэн лам нартай байж байгаад ноднингоос эхлэж хөөцөлдөөд шинэ дугана бариад Ганданчойнхорлин хийдийн манба дацанг байгуулаад байна. Анх 5 өвгөн лам байсан, 8 хүүхэд лам болгоод 13 ламтай 1993 онд Түвшинширээ суманд мөргөлийн өргөөг байгуулсан. Ноднин Бурхан багшийн 2550 жилийн ойгоор олон түмний дэмжлэгтэйгээр хөрөнгө мөнгө цуглуулаад сүм дугана барьж эхэлсэн тэгээд зуны тэргүүн сарын арван таванд нээлтээ хийж Ганданчойнхорлин хийд болгосон. Намайг тэргүүн гэдэг. Дөрвөн шавьтай. Хоёр нь Энэтхэгт сурдаг хоёр нь энд байдаг. Ийм л учиртай.

- Алтанбулагийн хийдээ мэдэх үү?

Алтанбулагийн одоо тэр лам нараас илүү хэлэх юм байхгүй.

-Бударганы хийд хэдэн оны үед байгуулагдсан ямар ноёны үед байгуулагдсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бударганы сүмийг 100 жилийн түүхтэй гэж ярьдаг байсан, 1932-1933 оны үед 100 жилийн түүхтэй байсан. Тэгэхдээ урьд Сэр дацан хийдийн дотроос эзэн хааны мэдлийн сүм ганцхан байсан юм гэнэ лээ. Чийга янпайтай гэдэг нь чийга нь өндөр юм байдаг. Янпай нь хаалгархуу юм байдаг. Чийга морины уяа, янпай эмээлийн тавиг юм байна лээ. Тэр тамгаар эзэн хаан ерөөсөө хийдүүдэд залрахдаа Бударгана дээр заларч тэр л хавь ойр,сүм, лам нартай уулзахдаа тэнд л очиж уулздаг эзэн хааны мэдлийн сүм байсан. Оргүй их туурь байгаа биз дээ. Суварга байгаа Цогчэн дуганы ор, суварганы баруун хойно том чулуун хүрээ байгаа. Чойрын хийд, тээр хойд жаахан толгой байгаа их суварга гэж байсан. Их суварганы баруун энгэрт нь Дүйнхорын сүм байсан. Хамгийн зүүн урд талд нь чулуун хүрээ байгаа. Тэр чулуун хүрээ бол Манбын дацан байсан. Ийм учиртай даа Суварга байсан толгойн баруун үзүүрт онцгойхон хүрээ байгаа. Тэнд нь Дүйнхорын дацан гэж байсан. Миний ах хийдэд сүүж байгаад баригдсан. Тэгээд хэлмэгдлийн 1 сая төгрөг өгсөн. Тэрнээс суварга, Түвшинширээ сумд сүмийн хойно хонх, суварга хоёрыг бий болгосон юм .

-Танай энэ шинэ байгуулаад байгаа хийд хүүчин Бударганы хийдийг сэргээсэн гэж үзэх үү?

Цагаан толгойн хийд, Бударганы хийд хоёрын явуулж байсан үйл ажиллагааг үргэлжлүүлэх санаатай шийдсэн. Тэр хоёр хийдийн ормыг л ертөнцөд байлгах юмсан гэж санаа нь тэр. Одоо бол би үүргээ биелүүллээ гэж бодож байгаа.

-Цагаантолгойн араар хүйтний хоёр худаг байна үү?

Манай хийдийн урдхан Хүйтний хоёр худаг бий.Одоо бол Манай сүмийг Түвшинширээ сумын Сэргэлэнгийн төвд байгаа Ганданчойнхорлин хийд гэж байгаа .

Бударганы хийдийн төвд нэр нь?

Бударганы хийд л гэдэг байсан ш дээ. Ловоон Бадмажунай сахиустай байсан юм. Цамтай, Гомботой . Одоо манай хийд бол Гомбо сахиустай, Алтан-Овоотой. Тэгээд тэр шинэ барьсан дуганаа Мамба дацан болгох санаатай.

-Бударганы хийдийн хурлын талаар?

Дом тавьдаг байсан. Би 3 жилийн дом тавьж байсыг үзсэн. Тэгэхээр 12 домтой байсан. Тэрэнд хамгийн их дом нь лам Цойнжид тэгээд Лянх тэгээд 12-ны Лхам дом жилдээ нийтдээ 12 дом тавьдаг байсан. Намартаа бол заавал гэвшийн мяндаг барьдаг. Хэдэн лам нар гэвш болдог. Дээр үед бол жинхэнэ чойрын ном мэддэг, дагсал хаялцдаг тийм лам нар л гэвш болж байсан юм гэнэ лээ. Миний мэдэхийн үед бол бараг л гэвшийн дамжаа хуруулчих чадалтай хүн л бараг чойрын ном оролдож байгаагүй. Дамжаа барихдаа хэдэн дагсалын хариу хүнээр заалгаж авчихаад л дэргэдээ Чойрын ном мэддэг лам гүйж одоогоор бол өмгөөлөгч гэдэг шиг дэргэдээ суулгачихаад тэгээд өөрөө хэдэн цанлинд хариу өгөөд, хэдхэн төрлийн цанлин тогтоож аваад тэр цанлингаа хүн асуухлаар нэг хэлчихээд бусад тэр дагсад хаях барих янз бүрийн юманд хажуудаа гүйж суулгасан лам нь л хариулаад тэгээд мяндаг тавьчихдаг тийм маягтай тэгээд гэвш болоод байдаг байсан.

-Бударганы хийдэд өөр ямар ямар хурал ном хурдаг байсан бэ?

Майдар эргэдэг байсан. Дүлцэн залдаг байсан. Их маани хурдаг байсан. Тэгээд сар бүрийн 3-нд, хоёр сар юмуу, 3 сар хавьцаа болоод л Арван хангал хурдаг байса. Сайн сайн гэвш, маарамба , аграмба байсан.Тоолоод бодвол бараг 30 гаруй лам байсан. Хутагт хувилгаад гэж олон хүний багш болсон Гомбо ламхай гэж нэг хувилгаан байсан. Тэр ламыг бол би дүрээр нь хараагүй. Таалал төгсөхөд нь Бударгана сүмийн баруун хойхно нь чандарласан юм гэнэ лээ. Зохиолч Д.Маам энэ урд талын Дарьганга чиглэлийн сүм хийдийг судлах гэж их явсан. “Газар шороо” романд хийдүүдийн тухай товчхон товчхон оруулсан байгаа.

-Бударганын хийдийн барилга ямар материалаар баригдсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Туйпуун дуганууд байсан. Хачин сайхаан. Ер нь монгол хүн барьсан тийм дуган гэж тэр үед байгаагүй байх аа. Миний мэдэхийн дуган сэлбэж байгаа гэж шавар нааж байхыг үзээгүй. Нэг гэр дугантай байсан. Өвөл тэндээ хурдаг. Тэр гэр дуганыг барина гээд босгоотой 8 багана байдаг байсан. Тэгээд Цэдэр хурахаас 10-аад хоногийн өмнө дуган барина гээд дуулдаад байсан. Гэр дуган барьсан. Тэрэнд 300-аад лам л 8 үе жавдантай сууж байсан цадиггүй том гэр байсан. Тэр жавдангуудын хоорондох зайд 4 тулга түлчихдэг. Тэгээд 20 хэдэн тулга тулаад гал түлээд цэдэрээ хурдэг байсан. Жинхэнэ сахиус нь бол Ловон. Жаахан хүүхэд болохлоор чинь юу ч мэдэлгүй дөнгөж л уншдаг юмаа уншихаад багшдаа загнуулахгүй л явж байхыг боддог байсан.

-Хийдийн мяндагтангуудыг та санаж байна уу?

Шарав хамба гэж лам байсан. Бизъяа хамба гэж лам байсан. Бизъяа хамба нь таалал төгсчихээд Шарав хамба гэж болсон. Дайчуу гавж гэж лам байсан. Ловон лам нь байсан. Би анх 5 настай очиход Бизъяа хамба гэдэг хүнээс адис авч байсан. Тэрний дараа Шарав хамба гэдэг хүн байсан. Тэгээд аранжинба багш гэж бүх шавь нарын бүгдийнх нь багш байсан. Тэр одоо бол цорж байсан юм. Самбуу гэдэг нэртэй хүн байсан юм. Хүн болгон л аранжинба багш л гэнэ. Маарамба лам нар хэд хэд байсан. Тэнд чинь одоо тэгээд сүмээс зайтай гэр мэр барьчихаад лүйжин тавьж байдаг байсан.

-Хэр олон лам нар ирдэг байсан бэ?

Тусгай жорж хийсэн 10-аад хүн л байдаг байсан. Тэр хурал хийдийн зүгээс хурж байсан юм уу, сүсэгтнүүдийн хүсэлтээр хуруулдаг байсан юм уу, тэрийг би мэдэхгүй байна. Тусгай хөндий хэдэн гэр барьчихаад л байсан. Би бас тэрэнд нэг их очиж мөргөж байгаагүй.

-Тэр хурал маань Бударганын хийдээсээ аль чигтэй байсан бэ?

Баруухан хойноо байсан. Суварганы баруун хойно нь нэг овоо байсан. Тэр тахидаг овоо нь байсан. Тэр баруунтаа нэг жаахан овоо байна. Тэр Лянхын овоо. Лянхын дом тавиад тэнд очиж наадам хийдэг байсан юм.

-Хийдийн унзад, гэсгүй нар нь хэн хэн гэдэг хүмүүс байсан бэ?

Олон байсан. Гончиг-Осор, Гочоо гэж сүүлийн хоёр том, айхтар унзад нар байсан. Чойрын унзад нь Ядам гэж хүн байсан.

-Чойрын шунлайв нь хэн байсан бэ?

Нэр нь орохгүй байна. Гэсгүй нь Санжаагончигдоо гэдэг хүн байсан. Молом той хурна гээд 3, 4 хоног хурдаг. 100 гаруй шавь лам нар байсан. Гурван өдөр Итгэлээс эхлээд Магтаал, Догшид, Ерөөлүүд цээжээр уншдаг байсан. Би багананд босоод тэр гурван өдрийн уншлаганд надад уншиж чаддаггүй ном байхгүй байсан. Тийм байсан. Таван хүүхэд үлддэг байсан юм. Надтай таван хүүхэд л үлддэг байсан. Тэгээд шүүдэг улс гээд багш нар нь байна. Одоо ер нь тэгж байгаа юм байна уу? Гиег гэж гэсгүй хүн. Гиег гэдэг хүн тэр хурлыг дэглэдэг байсан. Нэг мундаг том бэрээтэй, хоёр айхтар очир толгойтой модтой. Торго дурдан гээд баахан юм хажуу талдаа зүүсэн хаалгаар багтахгүй шахуу юм байдаг байсан. Тэр гурван өдөр ном уншихад чинь шүүж байгаа лам нар ичиглэнэ шүү дээ. Хурлын уншлаганы жор байдаг шүү дээ. Тэр жорын дагуу дэс дараагаар нь уншина. Номоо мэдэхгүй заалгаагүйг нь заалгаагүй ээ гээд шүүж байгаа улсууддаа хэлнэ. Тэгээд сууна. Заалгасан боловч өнөө унших юугаа мартчихсан бол дотоод хормойг нь эргүүлээд зогсоочихно. Тэгээд мартсан ном яваад дуусахаар за одоо сүү гээд суулгадаг байсан. Уншдаг хүүхэд бол уншсаар байгаад гурван өдрийг дуусгана. Тэгээд хамба ламын цонжоо хүртдэг байсан. Би тэр цонжоо гэдгийг хүртэж байсан. Цонжоо гэдэг нь яадаг юм гэхлээр зэрэг шагнал юм байна, шалгарч байгаа юм байна. Тэгээд хормойгоо бариад л адис аваад л боов шоов, хадаг яндар зэрэг янз бүрийн юм хийж өгөөд байдаг байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Нэг мэдэгдэж байгаа юм бол одоо Ганданд ямар нэртэй байдаг юм бэ дээ, манай тэр Бударганын хийдэд Цонж Чоймбол гэж нэг лам нарыг томилоод унзад, гэсгүй, ширээний лам, ловон лам, да лам гээд ширээнд суулгаад тэгж томилдог байсан. Мөн дүлцэн зална гэж нэг их сайхан ажил болдог байсан. Дүлцэнг 30-аад хоног бүтээдэг байсан байх.

-Дүлцэнг хэзээ бүтээдэг байсан бэ?

Хаврын дунд сар орчмоос хаврын адаг сарын 15 хүртэлх хугацаанд л бүтээх ёстой байсан. Тэгээд бүтээж чадна уу үгүй юу, тэгээд бүтээж чадвал хаврын адаг сараас зуны тэргүүн сарын шинийн нэгэн хүртэл нөгөө Дүлцэнгийнхээ цагийн хурлуудыг хурдаг байсан. Тэгээд хурж хурж л тэр бүтээсэн Дүлцэнгүүдийнхээ шороог аваад тэгээд юуг нь тавцан дээрээсээ үлдэгдлийг нь аваад бүх лам нар одоо жоовонтой, том ламаа морин тэргэнд жуузанд суулгаад хийдийн зүүхэнтээ 2 км 325 м хэртэй газар Бээлийн амнаас залдаг байсан. Тэнд устай булагтай, мал хүн амьтан ойртохгүй хамгаалалттай тийм булаг байсан.

Манай хийд Гэсэр залдаг байсан. Манайд гавжийн дамжаа барьдаг байсан. Харин тэр маарамба, энэ маарамба гэж байснаас маарамбын дамжаа барьж байгаагүй байх аа. Одоо ухаан маарамба гэдэг чинь оточ нар байна шүү дээ.

-Сүм хийд нураагдах үед Бударганын хийд ямархуу байсан бэ?

Сүм хийдийг тараах болсон шалтгааны талаар энэ түүх энэ тэрд байдаг юм байгаа биз дээ. Ер нь нийт ард түмний байдал их зовлонтой ихээхэн гутарч гуьнж байсан нэг хэсэг бий байх. Нэг хэсэг нь ч сүм хийдийнхээ юмыг олз болгож байсан ч улсууд бий. Хар болоод энд байхын аргагүй боллоо гээд урагшаа оргоод гарч байсан. Манай хийдээс олон сайхан лам нар унзад энэ тэр хүмүүс оргоод гарчихсан юм. Тэгээд Өвөр монголд гарчихсан. Одоо үхэж дууссан л даа. Миний нэг ах хүртэл урагшаа явчихаад Сөнөд цагаан овоогийн хийд гэдэгт сууж байгаад нас барсан гэнэ лээ.

-Ямар хүний захирамж тушаалаар буулгаж нураасан юм бол?

Тэрнийг одоо мэдэхгүй ээ. Тушаал гаргасан бол Намын төв хороо, Засгийн газар гэж байсан тэр л гаргасан байлгүй. Харин лам нарын баригддагийг би их учиртай гэж боддог. Гэндэн, Дэמיד гэж байсан. Тэрний хэнийг нь мэдэхгүй юм. Чойрын сүмийн хашаан дотор очиж гурав хоноод бүх лам нартай уулзсан. Томоохон лам нартай. Тэнд уулзсан бүх лам нар баригдсан. Нэг бүлэг л байгуулж явсан байгаа юм. Монголыг тусгаар улс байлгахгүй. Хятадын харъяанд өгье гэсэн тийм зорилготой бүлэг байсан. Тэгээд асуугдсан бүх лам нараас Жамбалцанжид мэдэх үү гээд мэднэ гэвэл л хороодог байсан байгаа юм.

-Яагаад тэгдэг байсан юм бол?

Жамбалцанжид тэр бүлгийнх нь ном байсан юм байгаа биз. Юманд их хүч оруулдаг ном шүү дээ.

-Хийд нураагдсаны дараа барилгыг нь юунд ашигласан бэ?

Манай тэр Бударганы хийдийн юмыг бол Дотоод Яамны харъяа

Наран хавиргын отряд гэж байсан. Тийшээ гол хэрэгтэй юмыг зөөгөөд тэрнийг зөөх хооронд тэр хавийн шуналтай улсууд юмнуудыг нь хулгайлж аваад одоо ганд гээд нэг их хүндтэй мод тэрийг Молломцоо хурахад л хамба лам, гэсгүй лам хоёр сожин уншсаны дараагаар хоёулаа хоёр мөрөн дээрээ тавьж ирээд хоёр талд нь хэд хэд цохидог. Тэгээд л аваачаад залчихдаг. Тэгээд тэр модыг хүртэл аваад зүсээд ташуур хийгээд зарж байсан дуулдана лээ.